



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.22 №37 (37)

ҮЙЛ ЯВДАЛ

УЛААНБААТАР ХОТОД ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ



Улаанбаатар хотод 120 цэгт 281 баг гаргаж, коронавируст урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг энэ сарын 23-наас буюу өнөөдрөөс үргэлжлүүлэхээр болжээ.

Хоёр дахь тунгийн хугацаа нь болсон болон нэгдүгээр тунд хамрагдаагүй иргэдийг вакцинжуулах бөгөөд хэдний өдөр хаана, аль цэгт вакцинд хамрагдахыг харьяа дүүрэг, хорооноос

танд утсаар мэдэгдэх аж. Хатуу хөл хорионы үед дархлаажуулалтыг зохион байгуулахдаа бөөгнөрөл үүсгэлгүй, иргэдийг чирэгдүүлэлгүйгээр ажиллах тал дээр холбогдох байгууллагууд анхаарч ажиллах юм.

ШҮХЭРЧИН ДАЙЧИД ӨӨРСДИЙН



Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн коронавирусийн цар тахлын үед үүрэг гүйцэтгэж буй Цэргийн төв эмнэлгийн эмч, ажилтнууд болон Тээврийн хяналтын албаны алба хаагчдад дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг гар ариутгагч, амны хаалтын хамт хандивлалаа.

Ангийн захирагч, хурандаа Д.Шинэбаяр “Энэхүү хандивын үйл ажиллагааг манай ангийн Ахлагчийн зөвлөл санаачилсан юм. Амаргүй энэ цаг үед иргэдийнхээ эрүүл энхийн манаанд хоёргүй сэтгэлээр зүтгэж буй цэргийн эмч нартаа болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахин хамгаалахад хяналт тавин ажилладаг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны хамт олондоо өчүүхэн сэтгэлийн дэм үзүүлж байгааг хүлээн авна уу”

гээд Цэргийн төв эмнэлгийн штабын дарга, хурандаа Д.Ганболд, Тээврийн хяналтын албаны дарга, хурандаа Л.Баярцогт нарт хандивыг хүлээлгэн өгсөн юм.

Мөн хурандаа Д.Ганболд “Бид бүгдийн үйл ажиллагааг чин сэтгэлээсээ дэмжсэн шүхэрчин дайчдадаа эмч, ажилтнуудынхаа нэрийн өмнөөс баярлаж байгаагаа илэрхийлэн ажлын өндөр амжилт хүсье” гээд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн хамт олонд хаягласан талархлыг гардуулав.



НОМТОЙ НӨХӨРЛҮҮЛЭХ ЦАХИМ ЗӨВЛӨГӨӨН БОЛНО



Өнөөдөр “Дэлхийн номын өдөр” тохиож байна. Энэхүү өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 340 дүгээр анги хугацаат цэргийн алба хаагчдыг номтой нөхөрлүүлэх зорилготой цахим зөвлөгөөнийг өнөөдөр 15-18:00 цагийн хооронд зохион байгуулна.

Тус зөвлөгөөнд “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүн, Философийн ухааны доктор, (Ph.D) профессор, гавьяат багш, дэд хурандаа Б.Галиндэв, Батлан хамгаалахын “Соёмбо” редакцын дарга, хурандаа С.Төмөрхуяг, Зэвсэгт хүчний Барилга инженерийн цэргийн удирдах газрын Цэргийн мэргэжлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, хошууч Б.Анужин, Батлан хамгаалах, ҮБХИС-ийн ЭШХ-ийн ЦТСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа Н.Хүдэрбат, ҮБХИС-ийн Төв номын сангийн эрхлэгч Ц.Мягмарсүрэн, “Болор-судар” хэвлэлийн газрын эрхлэгч Б.Уранболор болон тус ангийн хугацаат цэргийн алба хаагчид, тэдний эцэг эхийн төлөөлөл оролцох юм.

Энэ үеэр гавьяат багш Б.Галиндэв, “Дэлхийн сонгодог зохиол залуучуудын үзэл бодлыг төлөвшүүлэхэд ямар нөлөөтэй вэ”, дэд хурандаа Н.Хүдэрбат “Хувь хүний хөгжил, төлөвшил” зэрэг сэдвээр, мөн 340 дүгээр ангийн инженер, сапёрын ротын байлдагч Д.Жамъянсүрэн “Монголын түүхэнд тодорсон 33 цуут жанжин” номын талаар тус тус лекц уншина. Мөн хугацаат цэргийн алба хаагчид эрдэмтэн, багш, хүндэт зочдоос сонирхсон асуултдаа хариулт авч, хэлэлцүүлэг өрнүүлэх аж.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
22	6

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.403.00	3.462.00
CNY	437.00	441.40
RUB	36.70	38.30
JPY	26.10	26.60
KRW	2.46	2.60

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 11
2021.04.23.
/БААСАН ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН ГУРВАН ХӨХ
ЦАГААГЧИН ҮХЭРӨДӨР**

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно.

Наран ургах, шингэх:

05.48-19.53

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Шороо.

Аргын тооллын 4 дүгээр сарын 23, Сугар гараг. Билгийн тооллын 11, Бага морь одтой, цагаагчин үхэр өдөр. Өдрийн наран 5 цаг 48 минутад мандан, 19 цаг 53 минутад жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, лус тахих, рын ам арилжих, буг дарах, газрын ал бооход сайн. Цөөрөм байгуулах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

25.364+1328

ЭДГЭРСЭН

13.772

НАС БАРСАН

61/7

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1836 (16)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

308

ЭДГЭРСЭН

1512

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 142,557,268

Эдгэрсэн

Нийт: 122,879,555

Нас барсан

Нийт: 3,037,398

УЛААНБААТАР	23,141	БАЙРШИЛ
УЛААНБААТАР	23,141	1245
АРХАНГАЙ	255	321
БАЯН-ӨЛГИЙ	5	6
БАЯНХОНГОР	81	195
БУЛГАН	73	143
ГОВЬСҮМБЭР	37	5
ДАРЖАН-УУЛ	2	5
ДОРНОГОВЬ	407	5
ДОРНОД	22	5
ДУНДГОВЬ	59	5
ЗАВХАН	2	5
ЗӨВӨӨРӨЛГДСӨН	22	5
Орхон	445	5
Өвөрхангай	3	5
Сүхбаатар	3	5
Сэлэнгэ	3	5
Төв	3	5
Увс	3	5
Ховд	3	5
Хөвсгөл	3	5
Хэнтий	3	5
Тусгаарлалт хяналтад	133	0

2021.04.22

ҮЙЛ ЯВДАЛ

ЗУРГААН ХҮҮГЭЭ ЦЭРЭГТ ЯВУУЛСАН ЭЭЖ



зөв хүн болгох гэж ардын ухаанаар хүмүүжүүлсэн ч цэргийн алба олны дунд явах ухаанд сургадаг юм байна гэдгийг ойлгосон. Том хүү А.Бямбацогт Зэвсэгт хүчний 167 дугаар ангид алба хааж ирсний дараа дүү нар нь жил дараалан явцгаасан. Нэгийг нь хадаг, сүү бариад угтаж авч байхад нөгөөх нь “Баяртай, ээж ээ. Сайн сууж байгаарай” гээд цэргийн машинд суугаад явж байлаа шүү дээ” гээд хөвгүүдээ эр цэрэг болгосон талаараа хуучиллаа.

Түүний хэлсэнчлэн том хүү А.Бямбацогт Зэвсэгт хүчний 167, А.Мөнхбат Дорнод аймаг дахь Хилийн цэргийн ангид, А.Мөнхбаяр Зэвсэгт хүчний 119, А.Мягмардугар Зэвсэгт хүчний 336, А.Сэр-Од Зэвсэгт хүчний 326, бага хүү А.Отгонбаатар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд хугацаат цэргийн албыг тус тус нэр төртэй хаажээ. Тэднээс цэргийн албанд улирсан нь дунд хүү А.Мягмардугар, бага хүү А.Сэр-Од нар аж. А.Мягмардугар нь ахлагч цолтой, өдгөө Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд гал сөнөөгчөөр ажилладаг байна. Энхийг сахиулах ажиллагаанд гурван удаа үүрэг гүйцэтгэсэн туршлагатай. Бага

Энэ удаа эрхэм уншигч та бүхнийг цэрэгт элэгтэй жирийн нэгэн ээжтэй “уулзуулах” гэж байна. Цэрэгт элэгтэй гэсэн нь учиртай. Зургаан хүүгийнхээ Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн цэргийн жинхэнэ албыг биеэр хаах журамт үүргийг нь гүйцэтгүүлсэн эх оронч ээж буюу Төв аймгийн Сэргэлэн суманд ажиллаж амьдарч байгаа М.Баасанжаргал гуай юм. Тэрбээр зургаан хүү, хоёр охин төрүүлсэн



бөгөөд бүх хөвгүүдээ Зэвсэгт хүчинд цэргийн алба хаалгасан буурал юм санж. Энэ тухайгаа “Цэргийн албаар дамжсан хүн амьдралдаа барддаггүй, амжилтдаа сагадаггүй, ахархаж томордоггүй, хүнтэй харьцаж сурсан, бусдыг хүндэлдэг зөв хүмүүжил суудаг гол утга учир нь байгаа юм. Зэвсэгт хүчин миний хүүхдүүдийг эр хүн болгож хүмүүжүүлсэн буянтай салбар. Хөгшин бид хүүхдүүдээ

хүү А.Сэр-Од нь мөн ахлагч цолтой, тус нэгтгэлд харуулснаар ажилладаг, өдгөө БНӨСУ-д энхийг сахиулах үйлсэд зүтгэж байгаа гэнэ. М.Баасанжаргал гуайн зургаан хүүгээс гадна хүргэчүүл нь ч гэсэн Зэвсэгт хүчиндээ хугацаат цэргийн албаа хаасан гэдгийг сонсоод цэрэгт элэгтэй ээжээр бахархаж, хүндлэх сэтгэл аргагүй төрж байлаа.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ДЭЛХИЙН АХМАД ДАЙЧДЫН ХОЛБООНООС УРИЛГА ИРҮҮЛЖЭЭ

United Nations | Department of Economic and Social Affairs

Webinar Invitation:
Information Session for NGOs interested in applying for ECOSOC Consultative Status
Wednesday, 5 May 2021, 11:00 A.M - 12:30 P.M. EST

Join us to get answers to the following questions:

- ✓ What is Consultative Status, which organizations are eligible and what are its benefits?
- ✓ How the application process works from application submission to NGO Branch until ECOSOC decision?
- ✓ What are the main components of the application package?

Register at: <https://bit.ly/DESANGORegister> **Meeting will be conducted in English

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” ТББ-д Дэлхийн ахмад дайчдын холбооноос НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хорооны цахим зөвлөгөөнд оролцох урилгыг ирүүлжээ.

Сонирхсон Төрийн бус байгууллагууд энэхүү урилгын дагуу бүртгүүлж, тус зөвлөгөөнд оролцох боломжтой юм. Ташрамд, Дэлхийн ахмад дайчдын холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд өөрсдийн хувь нэмрээ оруулсан ахмад дайчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулахад оршдог. Мөн дэлхийн энх тайвны төлөөх үйлсэд олон жилийн дадлага, туршлагатай ахмадуудын мэдлэг, чадварыг ашиглаж, тэдний оролцоог дэмжсээр иржээ.

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАЛМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг “Соёмбо” сонин редакцалд бэлтгэв.

ЦАХИМ ШУУДАНД



ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Завхан аймгийн Улиастай, Тосонцэнгэл сумдад коронавирусын халдварын тоо нэмэгдсэнтэй холбогдуулан Завхан аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 4 дүгээр сарын 13-ны өдрөөс тэг зогсолт хийлээ.

Коронавирусийн цар тахлаас урьдчилан сэргийлэх,

халдварын тархалтыг хумих зорилгоор ЗХЖШ-ын даргын тушаалаар тус ангийн 25 цэргийн алба хаагч халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан Улиастай суманд гамшгаас хамгаалах, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох ажиллагаанд дэмжлэг үзүүлэн үүрэг гүйцэтгэж байна.

Ахмад Н.МӨНХБААТАР

ЗӨВЛӨМЖ

Шинэ коронавирус (Covid-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. Нэгтгэл, анги, байгууллагын байрлалд гаднаас нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах, гаднын хүн нэвтэрсэн тохиолдолд тухайн иргэний овог нэр, регистрийн дугаар, гэрийн хаяг зэргийг бичиж авч бүртгэл

5. Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтөд тодотгол хийж, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг эрчимжүүлэх;

6. Олныг хамарсан хурал, цуглаан, тэмцээн, уралдааныг зохион байгуулахгүй байх, сургалт

байр, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэх уусмалыг тогтмол байрлуулан сольж, шинэчлэх;

11. Шалган нэвтрүүлэх байранд ажиллах цэргийн алба хаагч амны хаалт тогтмол зүүж, гарын ариун цэврийг сахиж, нэг удаагийн бээлий өмсөх, амны хаалтыг 2 цаг тутам сольж, битүү таглаатай хогийн саванд зөв эвхэж хаяж, нэгдсэн устгалд оруулах;

NEW NORMAL SOCIAL DISTANCING



хөтлөх, нэгтгэл, анги, байгууллагын байрлалд нэвтэрч буй хүмүүст амны хаалт хэрэглэх шаардлага тавих, биеийн хэмийг шалгах, амны хаалтгүй болон халуурсан хүнийг нэвтрүүлэхгүй байх, үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний ангийн доторх хөдөлгөөнийг хязгаарлах;

2. Хугацаат цэргийн алба хаагчидтай ажиллах бүрэлдэхүүнийг 7-гоос доошгүй хоногоор томилгоожуулан ангийн байрлалаас гадагшлуулахгүй үүрэг гүйцэтгүүлэх, шинэ ээлжийг ПГУ /PCR/-ийн шинжилгээ хийлгэж, сөрөг гарсан бүрэлдэхүүнээр томилгоожуулах;

3. Ээлжийн амралттай, голомтын хөл хорионд байсан, гадуур томилогдон ажилласан бүрэлдэхүүнийг ПГУ /PCR/-ийн шинжилгээний хариуг үндэслэн нэгтгэл, ангийн байрлалд нэвтрүүлэх;

4. Шинжилгээнд хамрагдах томилгоот бүрэлдэхүүний нэрс, хаягийг ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэс /99087982, 99183504/-т томилгоот өдрөөс 1 хоногийн өмнө бүртгүүлж, цаг авах;

сурталчилгааны арга хэмжээг цахим хэлбэрт шилжүүлэх, бие бүрэлдэхүүнийг шинэ коронавирусын халдварын талаар баталгатай эх сурвалжаас авсан үнэн бодит мэдээллээр хангах;

7. Халдвараас сэргийлэх зөвлөмжийг бие бүрэлдэхүүнд танилцуулахаар ангийн гал тогоо, цайны газар, цэргийн байр, шалган нэвтрүүлэх байр, штаб зэрэг газруудад байрлуулах;

8. Цайны газрыг зөвхөн харуул, хоногийн манааны томилгоот бүрэлдэхүүнд үйлчлэхээр зохион байгуулж, хоолны өмнө гар угаах, ариутгах нөхцөлөөр ханган, хооллох үед хүн хоорондын зайг баруулах, бусад бүрэлдэхүүн өдрийн хоолыг гэртээ бэлтгэн ирэх зэргээр хооллолтыг зохион байгуулах;

9. Байнгын байрлал, өрөө тасалгаа, гадна болон дотор ариун цэврийн өрөө, бие засах газар, хог хаях цэгт ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж, бүртгэл хөтлөх;

10. Гал тогоо, цайны газар, шалган нэвтрүүлэх байр, цэргийн

12. Цэргийн байр, өрөө тасалгааны чийгтэй цэвэрлэгээг тогтмолжуулж, агаар сэлгэлтийг 2 цаг тутамд хийж, хэт ягаан туяаны гэрэл /кварц/, “Жавелин”-ны 0.003 хувийн уусмалаар агаарын ариутгалыг өдөр бүр, 0.006 хувийн уусмалаар гадаргуугийн ариутгалыг 3-4 цаг тутам тогтмол хийж;

13. Нэгтгэл, анги, байгууллагуудын эмнэлгүүдийн түр тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах;

14. Хугацаат цэргийн алба хаагчдын биеийн халууныг өглөө, орой 2 удаа үзэж, тэмдэглэл хөтлөн, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийн мэдээг ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлэх;

15. Бие бүрэлдэхүүний дунд халдварын тандалт судалгааг цахим хэлбэрээр эсвэл утсан холбоо ашиглан явуулах, дүнг нь ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст тогтмол мэдээлэх.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС

*Зар, рекламг хямд нийтэлнэ.
*Зар, рекламг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонинг нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонинг мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029